



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/15

Булган сум

Барилга байгууламж паспортжуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1. дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.1.2, 21.15, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дугаар заалтууд, Монгол улсын Шадар сайдын 2017 оны 78 тушаалаар батлагдсан "Барилга, байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журам", БНБД 20-01-11 Барилгын бүтээц ба буурийн найдваршил Ерөнхий шаардлага, Зам тээвэр барилга хот байгуулалтын сайдын 2012 оны 160, БНБД 22-01-21 Газар хөдлөлтийн бус нутагт барилга төлөвлөх Барилга хот байгуулалтын сайдын 2021 оны 117, БД 22-105-18 Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 185, БД 31-101-00 Эвдрэл гэмтэлтэй барилга байгууламжид инженерийн биет судалгаа явуулах аргачилсан заавар Дэд бүтцийн сайдын 2000 оны 94, БД 31-102-00 Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар Дэд бүтцийн сайдын 2000 оны 94, "БД 31-103-00, Барилга байгууламжийн бүтээцэд техникийн дүгнэлт гаргах ажлын жишиг үнэ" "Газар хөдлөлтийн бүсэд барьсан барилгын паспортжуулалтын аргачилсан заавар" Дэд бүтцийн сайдын 2000 оны 94 дугаар тушаалуудаар батлагдсан норм дүрмүүд "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.4 3.1 дугаар заалт, аймгийн ИТХ-ын 2022 оны 21 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Булган аймагт ашиглагдаж байгаа инженерийн хийцтэй барилгуудаас эхний ээлжинд зайлшгүй паспортжуулах шаардлагатай барилгын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
- 2.Паспортжуулах шаардлагатай барилга байгууламжуудад үзлэг хийх техникийн даалгавар гаргаж Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн/-д даалгасугай.
- 3.Батлагдсан техникийн даалгаварын дагуу зөвлөх үйлчилгээний тендерийг хууль, дүрэм, журамд нийцүүлэн зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Орон нутгийн өмчийн газар /Т.Баттулга/-т үүрэг болгосугай.
- 4.Шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах, ажлын явцад хяналт тавих, тооцоо судлагааны материалыг хүлээж авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Ү.Бямбасүрэн /-т даалгасугай.
- 5.Гэрээнд заагдсан санхүүжилтийг батлагдсан хөрөнгө оруулалт /тухайн төсөвлөсөн төсөл арга хэмжээний санхүүжилтаас/-аас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Д.Батцогт/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

6322011145

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын
...20...-ны өдрийн А/15 дугаар захирамжийн хавсралт



2023 онд үзлэг хийж гэрчилгээжүүлэх барилга байгууламжууд

- 1.Булган сумын төвд МСҮТ-ийн дадлагын байр хуучин модны үйлдвэр байсан
- 2.Сэлэнгэ сумын ЕБС-ийн даралтат цамхаг
- 3.Аймгийн нэгдсэн эмнэлгийн төв байр
- 4.Тэшиг сумын соёлын төвийн барилга
- 5.Хутаг-Өндөр 320 суудалтай хичээлийн байр
- 6.Гурванбулаг булаг сумын ЕБС-ийн 80 ортой дотуур байрны барилга
- 7.Дашинчилэн сумын хүүхдийн цэцэрлэг
- 8.Орхон сумын соёлын төвийн барилга
- 9.Хялганат Сэлэнгэ мөрний гүүр
- 10.Булган сумын 1-р сургуулийн 2 давхар дотуур байр